



П.БАТХҮҮ:

## “RED ROCK RESORT AND CONFERENCE CENTER” БОЛ БИЗНЕСИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫГ ХӨГЖҮҮЛЭХ ТОМООХОН ЭХЛЭЛ



Монгол орны хувьд аялал жуулчлалын салбар харьцангуй шинэ залуу салбар бөгөөд гагцхүү байгалийн үзэсгэлэнт тогтоц, нүд булаам онгон дагшин үзэмжээр жуулчдын харааг татсаар ирсэн билээ. Жил ирэх тусам аялал жуулчлалын тухай яриа, салбарын хөгжлийн талаарх санал бодлууд улам бүр өргөн хүрээг хамарч байна. Чухам энэ үед MICE буюу бизнесийн аялал жуулчлалыг хөгжүүлэх, олон улсын түвшинд хүргэх зорилготой ажлууд ар араасаа хэрэгжиж эхэлсэн юм. Энэ бол Горхи Тэрэлжийн үзэсгэлэнт байгальд орших “Red Rock” цогцолбор. Олон улсын туршлагаас харвал хуралчуулган, бизнес уулзалт, зөвлөгөөн, үзэсгэлэнгийн аялал жуулчлалыг байгалийн үзэмжит газарт байгуулсан цогцолбор, төвүүдэд зохион байгуулах нь элбэг. Үүнийг MICE гэж нэрлэдэг. Сүүлийн үеийн техник тоног төхөөрөмж, орчин үеийн минималист интерьер шийдэл бүхий зохион байгуулалттай, дэлхийн стандартад нийцсэн иж бүрэн тохижилттой “Red Rock” цогцолбор нь MICE-ийг зохион байгуулах хамгийн тохиромжтой газар юм. Ингээд та бүхэнд тус цогцолборын Гүйцэтгэх захирал П.Батхүүтэй хийсэн ярилцлагыг хүргэж байна.

Монгол улсын аялал жуулчлалын салбарт шинэ хуудас нээсэн газар бол “Red Rock” цогцолбор юм. Байгууллагын талаар болоод тус салбарт анх орсон түүхээс яриагаа эхэлье?

“RED ROCK RESORT AND CONFERENCE CENTER” буюу MICE-ийг зохион байгуулах төвийг бүтээн байгуулах санал санаачилга 2012 онд анх гарсан. Ингээд дөрвөн жилийн турш асар өргөн бүтэцтэй бүтээн байгуулалтын ажлууд эхэлж 2016 онд Улсын баяр наадмын өмнөхөн шинэхэн цогцолбороо албан ёсоор нээн үйл ажиллагаагаа эхэлсэн түүхтэй. Манай амралтын газрын үйл ажиллагааны гол чиглэл бол MICE-ийг байгалийн үзэсгэлэн цогцолсон тав тухтай орчинд олон улсын стандартын дагуу чанарын өндөр түвшинд зохион байгуулахаас гадна гадаадын болоод дотоодын аялагч, жуулчдад зориулсан цогц үйлчилгээг үзүүлэхэд оршиж байгаа юм.

“Red Rock” амралтын газрыг зорих бизнес эрхлэгчид, хувь хүмүүс олон болсон. Үйлчлүүлэгчдэд үйлчилгээний ямар төрлийн загваруудыг санал болгон ажиллаж байна вэ?

Сүүлийн үед байгууллагууд хотоос гарч вакуум орчинд үр дүнтэй хурал зөвлөгөөн хийхийг эрмэлздэг болсон байна. Бидний зорилго ч үүнд оршиж байгаа юм. Тиймээс бид олон улсын болоод Монголын байгууллагууд бизнесийн таатай орчин нөхцөлд хамгийн үр дүнтэй хурал зөвлөгөөн хийхэд туслах нэгэн гүүр болж байна гэсэн үг. Бидний санал

болгодог уулзалтын танхимууд сүүлийн үеийн техникээр иж бүрэн тоноглогдсон бөгөөд хувийн компьютероо авч ирээд ажиллахад ямар ч саадгүй ажиллах бүхий л нөхцөлийг бүрдүүлж өгсөн. Удаан хугацаагаар ажиллахад тохиромжтой сандал, ширээ, тавилга, хэрэгслээр иж бүрэн хангагдсан бөгөөд тэдгээр нь эргономикийн бүхий л шаардлагад нийцсэн гэдгийг тэмдэглэхэд таатай байна. Мөн бидний зүгээс аюулгүй ажиллагаа, нууцын зэрэглэлийг дээд түвшинд зохион байгуулсан учир үйлчлүүлэгчдийн итгэлийг бүрэн хүлээсэн найдвартай үйлчилгээг үзүүлж байна. Хурал зөвлөгөөнд чиглэсэн үйл ажиллагаанаас гадна гадаад дотоодын аялагч, жуулчдын ая тухтай амрах нөхцлийг бүрдүүлэн ажиллаж байна.

Тус цогцолборт хэдэн төрлийн хурлын танхим байрлаж байна вэ?

Бид үйл ажиллагаагаа эхэлснээс хойш томоохон форум, ТУЗ-ийн хурал, төрөл бүрийн сургалт, семинар, хурал, байгууллагуудын арга хэмжээг тогтмол зохион байгуулж байна. Тиймээс зориулалт, хүчин чадлаас хамаараад долоон төрлийн танхим ажиллуулдаг. Багийн ажиллагаатай сургалт хийх зориулалт бүхий “X-training” өрөө, 400 хүний багтаамжтай хурлын танхим, 20-30 хүн хүлээн авах боломжтой бизнес өрөө, 20 хүртэлх хүний их гэр гэх мэтээр бий.



Хурлын танхимууд бүгд сүүлийн үеийн техникээр тоноглогдсон гэсэн. Ямар онцлогтой техник, хэрэгслүүд гэдгийг дэлгэрүүлэн тайлбарлавал? Мэдээж хурлын танхимд тавилга хэрэгслээс эхлээд шаардлагатай зүйлс олон бий. Бид мэргэжлийн судалгааны дүнд хурал, уулзалт зохион байгуулахад зориулагдсан Английн алдарт “Burgess” брэндийн тавилгаар тохижуулсан юм. Дотор засалд дуу шингээгч тусгай материал ашиглаж, америк, европ, солонгос, хятадын тухайн чиглэлээрээ хамгийн сайн, чанартай гэсэн орчин

P.BATKHUU:

## “RED ROCK RESORT AND CONFERENCE CENTER” IS A BIG START TO DEVELOP BUSINESS TOURISM

Tourism is a comparatively new sector in Mongolia. The country attracts tourists due to its picturesque natural formation and ravishing virgin beauty. For the last years discussions about tourism and ideas of this sector's development expands to a wider sphere. Actually, at this period MICE or targeted activities to develop business tourism to the international standard began to be implemented one behind the other. It is the “Red Rock” complex located in the scenic nature Gorkhi Terelj. Judging from the international experience, it is common to arrange conferences, business meetings, discussions, exhibit tourism in scenic areas of nature. It is called MICE. The “Red Rock” complex is the most perfect place to arrange MICE, since it is fully furnished with the latest equipment and modern minimalist interior solution which meet the world standard. And we're bringing to you our interview with Mr.P.Batkhuu, CEO of the “Red Rock” complex.

The “Red Rock” complex opened a new page in tourism of Mongolia. Let's begin talking about history of your resort and when you first joined tourism?

The initiative to build “RED ROCK RESORT AND CONFERENCE CENTER” or MICE center was displayed in 2012 first. And a tremendous construction work had been done during four years. The official opening of a new complex took place just before the Naadam in 2016. It operates since then. The main focus of our resort activities is to arrange MICE in a quite environment of natural beauty in accordance with the international standard. Besides, we want to provide a set of services to foreign and domestic tourists.

Businessmen and individuals who visit the “Red Rock” resort increases. What kinds of services do you offer the customers?

Recently, the institutions strive for organizing conferences and meetings in a vacuum environment out of town to ensure effectiveness. It is also our goal. It means we are becoming a bridge to help international as well as Mongolian institutions in arrangement of the most effective conferences and meetings in a cozy business environment. We offer conference halls fully furnished with the latest equipment, and have created all conditions



үеийн тоног төхөөрөмж авч суурилуулсан болно.

**Үйлчлүүлэгчдийн дийлэнх хувийг гадаадын зочид төлөөлөгч, жуулчид эзэлж байна уу? Эсвэл дотоодын амрагчид эзэлж байна уу?**

Өнгөрсөн долоон сараас хойших статистик мэдээллийг дүгнэж харвал, манай үйлчлүүлэгчдийн дийлэнх нь байгууллага хамт олон байна. Тэдгээрийн дотор Монгол улсад төсөл хэрэгжүүлж буй олон улсын байгууллагууд, элчин сайдын яамд, бизнесийн томоохон компаниуд багтаж байна. Мөн гадаадын жуулчид, гэр бүлээрээ амарч аялах хүмүүст манай үүд хаалга үргэлж нээлттэй гэдгийг хэлмээр байна.

**"Red Rock" цогцолборт бизнес уулзалт, хурал хийхийн сацуу чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх ямар таатай боломжууд байгаа бол?**

Мэдээж бид байгалийн үзэмжит газарт байрлаж байгаа учраас чөлөөт цагаа ая тухтай өнгөрүүлж аялж зугаалахад тохиромжтой бүхий л бололцоог хангасан. Үүнд сагсанбөмбөг, волейбол, хөлбөмбөг, газрын теннис тоглоход зориулагдсан олон улсын стандартыг хангасан талбайнууд багтаж байна. Мөн UTV мотоцикль хөлөглөн байгальд аялж болохоос гадна морин аялал хийж болох юм. Үүнээс гадна түүхийн дурсгалт газрууд болох "Мэлхий хад", "100 ламын агуй", "Гүнжийн сүм"-ийг нэг дор үзэн аялж болохоороо онцлогтой.

**Хамгийн их ачаалалтай үе хэзээ таардаг тухай болоод амралтаа дурсамжтай өнгөрүүлэхэд тохирох улирлын талаар зөвлөвөл?**

Манай байгууллага үйл ажиллагаагаа эхлүүлээд удаагүй ч цаашид зуны улиралд өндөр ачаалалтай байх болов уу гэж харж байна. Өнгөрсөн хугацаанд улирал харгалзахгүй жигд ачаалалтай байсан. Харин

that visitors can bring along their personal computers and work without difficulty. It is a pleasure to mention that furnishings such as tables and chairs suitable for a lengthy work are fully provided and satisfy all ergonomic standards. In addition, we provide a reliable service trusted by customers, since we've arranged security and secret classification at a high level. Apart from the activities involved in conferences and meetings, we provide conditions for a quite rest of foreign and domestic tourists.

**What types of conference halls does the Complex accommodate?**

Since the start of our operation, we organize big forums, meetings of MCR, different trainings and seminars, conventions and organizations' event on a regular basis. Therefore, we operate seven different halls in dependency of purpose and capacity. We have an "X-training" room for training in team, a conference hall with capacity of 400 persons, a business room for 20-30 persons and a big ger for 20 persons.

**You've said all conference halls are furnished with the latest equipment. Please detail the feature of equipment and appliances?**

Matter of fact, there are plenty of necessary things in the conference hall, including furnishings. As the result of a professional study, we have furnished our conference halls with famous British brand "Burgess". A sound-absorbing material has been used in interior decoration and the best quality modern equipment manufactured in America, Europe, Korea and China has been installed.

**Do the foreign visitors and tourists make majority of your customers, or domestic holiday-makers?**

Judging from the statistics as of the last seven



months, majority of customers have been people from institutions and communities. International organizations implementing a project in Mongolia, embassies and big business companies are among them. Also, I would like to say that our door is always open to foreign tourists and family travelers.

**What are the possibilities to spend free time nicely at the "Red Rock", while having a business conference or meeting?**

Matter of course, we are located in an area of natural beauty, therefore, we've ensured all possibilities suitable for visitors to travel and to go for a stroll to spend their free time nicely. It includes playfields that satisfy the international standard for playing basketball, volleyball, football and soft tennis. In addition, it is possible to travel in nature by UTV motor-cycle and have a horse trip. Apart from the above, visitors can go about to see historical memorable places like Turtle Rock, "Hundred Lamas Cave" and "Gunjiin Sum".

**When is the peak period for the resort? Which season do you recommend in order people can spend their holiday nicely to reminisce later?**

It has been not long since our resort began functioning. However, we expect a high overload in summer the years to come. In the past our workload was regular regardless of seasons. If examine by week, we are overloaded in weekends. The winter is most appropriate for people who want to enjoy natural beauty and to remove stress. Everybody knows nature in Gorkhi Terelj is incomparably beautiful in summer, also.

**What standard do you implement in operation?**

Our resort became the first organization received a certificate "IACC certified venue" granted by the professional council of the International Conference Center in March last year. Satisfaction of the requirement means that we can organize any small and medium-size conference or meeting at the professional level.

**Please tell us about the capacity of your resort. How many customers can you provide service at one go?**

The conference hall can accommodate 500 persons maximum. Our hotel can accommodate 150 persons at one go. As for the restaurant, 200 customers can

долоо хоногоор нь авч үзвэл амралтын өдрүүдэд ачаалалтай байна. Байгалийн үзэсгэлэнг харж, алжаалаа тайлахыг хүсвэл өвлийн улирал хамгийн таатай. Мөн Горхи-Тэрэлжийн байгаль зуны улиралд ч хосгүй сайхан гэдгийг бүгд мэдэж байгаа байх.

**Та бүхэн үйл ажиллагаандаа ямар стандартыг хэрэгжүүлэн ажилладаг вэ?**

Бид өнгөрөгч гуравдугаар сард Олон улсын хурал зөвлөгөөний /conference center/ мэргэжлийн зөвлөлөөс олгодог "IACC certified venue"-ийн сертификатыг монголдоо авсан анхны байгууллага болсон юм. Тус болзлыг хангаснаараа олон улсын шинж чанартай жижиг, дунд хэмжээний ямар ч хурал, уулзалтыг мэргэжлийн түвшинд зохион байгуулах боломжтой болсон гэсэн үг.

**Байгууллагын хүчин чадлын хувьд дэлгэрүүлж яриач? Нэг дор хэдэн зочинд үйлчлэх боломжтой вэ?**

Бид хурлын танхимдаа дээд тал нь 500 хүн хүлээж авах хүчин чадалтай. Байрлах байрны хувьд нэг дор 150 хүнд, рестораны хувьд 200 зочинд зэрэг үйлчлэх боломжтой. Мөн манайхаар зочилж ажлаа амжуулахын зэрэгцээ виолоунж, караоке, диско бар, гэр лоунжаар үйлчлүүлэх давхар боломж бий. Буудлын хувьд фитнес, теннис, иогоор хичээллэх танхим, хүүхдийн өрөө, массаж гээд амарч зугаалахад авч болох бүхий л төрлийн үйлчилгээг шийдэж өгснөөрөө онцлог юм. Мэдээж үнэгүй интернет, зурагт, эрүүл хоол хүнсийг зочдодоо санал болгодог. Хамгийн гол нь манайд хүрэлцэн ирсэн зочид ямар нэг шинэ санаа олж, авангаа алжаалаа тайлаад яваасай гэж бид хүсдэг. Тиймээс хүний хэрэгцээнд шаардлагатай бүхий л зүйлсийг бэлтгэсэн гэж хэлж болно.



**Та ойрын болоод урт хугацаанд төлөвлөж буй ажил, зорилтуудаасаа бидэнтэй хуваалцаач?**

Бидний хамгийн гол зорилго болаливаа хурал, зөвлөгөөн, ажил хэрэгч уулзалтуудыг орчин үеийн түвшинд үр дүнтэй зохион байгуулахад мэргэжлийн туслалцаа үзүүлэх юм. Тийм ч учраас бид өөрсдийн сургалтын баг байгуулахаар зорьж байгаа юм. Мөн олон нийтийн арга хэмжээ, баяр, тэмдэглэлт үйл явдлыг зохион байгуулдаг мэргэжлийн баг бүрдүүлж байна. Энэ баг захиалга өгсөн байгууллагын хүсэлтийн дагуу шаардлагатай хөтөлбөр, зохион байгуулалтыг хийж бүхий л шатны ажлыг гүйцэтгэнэ гэсэн үг л дээ. Мөн багийн ажиллагааны сургалт хийхэд зориулагдсан янз бүрийн чадвар сорьсон гадаа талбайг бэлдэж байна. Цаашилбал, байшин дотор хурал хийхээс гадна эрүүл агаарт багаараа ажиллах боломжийг бүрдүүлж байгаагаас гадна сургалтыг төрөл бүрийн сонирхолтой хэлбэрээр зохион байгуулах, олон нийтийн арга хэмжээг иж бүрнээр чанарын өндөр түвшинд хийж гүйцэтгэхийг зорьж тэмүүлэн ажиллаж байна. Мэдээж байгалийн үзэмжит газарт байрлаж байгаа учраас уул хаданд авирах, явган аялал хийх, уулын дугуйн зам, өвлийн улиралд цана чаргаа гулгах гэх мэт чөлөөт цагаа боловсон өнгөрүүлэхэд туслах боломжит үйлчилгээнүүдийг нэвтрүүлэхээр зорьж байгаа.

**Та бүхэн зорилтот үйлчлүүлэгчдээ хэрхэн тодорхойлж байна вэ?**

Бүх төрлийн байгууллага хамт олон, ажил хэрэгч хүмүүс, аялагч, жуулчид, мөн мэдээж гэр бүлээрээ амарч байгаа дотоодын амрагчдадаа бид үйлчилгээгээ зориулж байна.

**“Red Rock” амралтын газрын бүтээн байгуулалт, интерьер хүмүүсийн анхаарлыг их татдаг. Бүтээн**

be served together. In addition, visitors have additional possibilities to get service in wine lounge, karaoke, disco bar and ger lounge. The hotel's special feature is that it provides all kinds of services needed in travel or rest such as fitness, tennis, and hall for yoga training, children's room and massage. Matter of fact, guests is offered free Internet, TV and healthy food. Most importantly, we wish visiting guests to find some new idea while removing their stress. Therefore, it can be said everything that needs for an individual's need has been prepared.

**Please share with us your immediate and long-term goals and plan of activities?**

Our main goal is to provide professional help in effective organization of any conference, discussion and business meeting. Therefore, we want to set up our own training team. Also, we are forming a professional team for public events, festivities and celebrations of memorable events. This team will work out a necessary program and make arrangements at every instance according to the organization's order. In addition, we are preparing an outside field for training team activities to experiment various abilities. Moreover, we're striving to create possibility for team work in fresh air, apart from holding a conference in a room, and to arrange training in a different interesting form and public events comprehensively on a high quality level. Since we are located in scenic area of nature, we want to introduce all sorts of possible services which promote visitors to spend their leisure properly. These include hiking, foot trip, and mountainbike road, skiing and skating in winter.

**What are your targeted customers?**

We provide services to different institutions, business people, tourists, and also domestic family holiday-makers.

Building of the “Red Rock” resort and its interior are

**байгуулалтын ажлын талаар дэлгэрэнгүй ярьж өгөөч?**

Бид маш нарийн судалгааны үндсэнд бүтээн байгуулалтын ажлаа эхэлсэн. Монгол орны уур амьсгал, нөхцөл байдлыг харгалзан үзэж загвар шийдлүүдийг нь олон дахин засварлан сайжруулсаар өнөөдрийн “Red Rock” бий болсон. Жишээ нь, Монголчуудын үнэт өв соёлын нэг Монгол гэрийг бид орчин үеийн шийдлүүдээр баяжуулан цонх, хаалгатай баганагүй болгон тооно нь дээш нээгддэг байхаар бүтээсэн. Ийнхүү цоо шинэ байдлаар монгол гэрийг бүтээсэн нь үйлчлүүлэгчдэд маань маш их таалагдаж байгаа. Хурал уулзалтын танхим, буудлын өрөөний орон зай, байрлал, тавилга, гэрэлтүүлэг зэрэгт ч нарийн анхаарч судалгаа тооцоо, тоо шингээн бүтээсэн. Өөрөөр хэлбэл, барилгынхаа жижиг деталь бүрт анхаарч ажилласан. Мэдээж интерьер дизайны хувьд ч нэлээд анхаарч, шинэлэг байхаар хичээсэн. Өөрөөр хэлбэл, бүхнийг хэрэглэгчдийн байр сууринаас урьдчилан харж тооцоолсон учраас хүмүүсийн эрэлт хэрэгцээнд нийцдэг. Дүгнэж хэлэхэд, бид үйлчлүүлэгчдэдээ гэртээ байгаа юм шиг ая тухтай дулаан мэдрэмжийг төрүүлэхийг зорьсон юм.

**Монгол гэрийнхээ талаар дэлгэрүүлэн ярьж өгнөөү? Орчин үеийн шинэлэг шийдлээр баяжуулан бүтээхдээ чухам яагаад ийм хэлбэр загварыг сонгосон бэ?**

Манай Монгол гэр мянгатын мөнгөн дэвсгэрт дээр байдаг “цомцог” хэмээн нэрлэгддэг эртний загвараар бүтээгдсэн. Тэр гэрийн ерөнхий санааг нь авч загвар дизайныг нь шинэлэг шийдлүүдээр баяжуулан бүтээсэн юм. Үүний тулд гэрийг мэргэжлийн зураг төслийн программаар тооцоолон зурж, ямар харьцаатай байвал илүү ая тухтай байхыг бодолцож хийсэн. Тиймээс гэрт ороход толгой цохигддоггүй, хойморт суугаад орчин тойрны байгалийг чөлөөтэй харах боломжтойгоос гадна уужим зайтай. Шалны халаалтыг орчин үеийн технологиор шийдсэн тул өвлийн улиралд ч тав тухтай. Зуны улиралд хаяаг нь шуугаад тооныг нь нээх боломжтой тул агаар сэлгэн сэрүүхэн сайхан байдаг юм. Эсгий гэрийн цөөн хэдхэн дутагдал бол салхи салхилахад тогтворгүй байх, эсгийний үнэр, бороо ороход яндан болон тооноор дусаал дусах юм. Энэ бүхнийг бид эерэгээр бүрэн шийдсэн. Манай гэрүүдийн хойморт суугаад цай уунгаа үүдээр нь Чингис уулыг харах нь бас л нэгэн таашаалыг төрүүлнэ. Монгол хүн бүр гэрт дуртай. Харин шинэлэг маягийн монгол гэр маань амрагчдын сонирхлыг бүр ч их татдаг.

**Та бүхэн амрагчдадаа монгол гэрээс гадна модон байшинд амрахыг санал болгодог юм байна. Байшинд амрах юугаараа онцлог вэ?**

Байшин маань гэр бүлээрээ амарч байгаа хүмүүст нэн тохиромжтой. Дотроо унтлагын болон ариун цэврийн, гал тогооны өрөө гээд өнөр бүлд



**attractive to visitors. Please tell us about the construction?**

We began erecting the construction after a very careful study. The current “Red Rock” has come into being due to repeated improvements of design solutions in consideration of weather conditions in Mongolia. For instance, Mongolger is one of the cultural heritages of the Mongolians. We erected a modern designed ger with a door, a window and a roof-ring, but without pillars. Customers like it very much. Based on study and assessment, we gave a careful consideration to conference halls, hotel room's space, location, furniture and lightening. In a word, we paid attention to every detail of the building. Naturally, we gave a considerable attention to the interior design to make it most modern. Everything was foreseen on the part of customers; therefore, it meets visitors' demands. Speaking as a conclusion, we wanted our customers to have comfortable feelings as if they were at home.

**Could you tell us more about your Mongol Ger? What is the reason of selecting this particular pattern?**

Our Ger is created in an ancient pattern called “Tsomog” found on the banknote of 1000Tg. The idea was taken from it, but in a new design. In doing it, we used a professional design program, considering a better proportion to ensure comfort. Therefore, customers do not knock their head against the door board. The wide space provided inside the Ger enables guests sitting in the honored place behind the hearth to see the natural surroundings freely. The Ger is very comfortable also in winter, since its floor heating has been solved by the latest technology. The Ger is cool and nice to stay in as it is possible to truss up its skirts and open its roof-ring. The felt ger has some problems, including its instability in wind, felt smell and drips along the pipe and from the roof-ring when it rains. We've solved these problems positively. Our ger provides a pleasure to look at Chinggis mountain while sitting in its honored place and enjoying tea. Every



хэрэгцээтэй бүхий л орчинг бүрдүүлсэн. Модны анхилам сайхан үнэртав тухтай байдал нь амрагчдад хамгийн сайхан амралтыг бэлэглэдэг.

**Таны ярианаас "Red Rock" амралтын газар аялал жуулчлалын салбарт шинэ өнгө төрх нэвтрүүлж байна гэж ойлголоо. Эцэст нь дүгнээд энэ бүх ажлыг хэрэгжүүлдэг танай хамт олны ажлын зарчим, үйлчилгээндээ баримталдаг менежментийн талаар ярьж өгөөч?**

Манай бүх ажилтан хоорондоо уялдаа холбоотой ажиллахын зэрэгцээ, удирдах түвшний ажилтнууд ч өдөр тутмын үйл ажиллагаандаа ямагт оролцдог. Хүн бүр ажилдаа чин сэтгэлээсээ хандан хэрэглэгчдэдээ ойр элэгсэг байснаар үйлчилгээгээ оновчтой, үр дүнтэй, чанартай байлгахад хэрэгтэй мэдээллийг алхам тутамдаа олж авч байдаг. Бид нээгдсэнээсээ хойш ямар нэг маркетинг, зар сурталчилгаа хийгээгүй. Ирж амарсан хүмүүсээс сонсон биднийг зорьж ирж үйлчлүүлдэг нь бидний ажлын бас нэгэн үзүүлэлт биз ээ. Оновчтой менежмент, сэтгэл шингэсэн үйлчилгээ, тав тухтай орчин энэ бүхэн нийлээд чанартай үйл ажиллагааг бүрдүүлж, сэтгэл ханамжийг төрүүлнэ. Ийм замаар аялал жуулчлалын үйлчилгээний салбарт шинэлэг жишиг тогтоон ажиллаж байна. Тиймээс бид үйл ажиллагааныхаа деталь бүрт анхаарч мэдрэмжтэй ажилладаг.

**Ярилцсанд баярлалаа. Та бүхний цаашдын ажилд амжилт хүсье!**

Mongolian likes ger. A newly designed Mongol ger attracts an interest of holiday-makers very much.

**You offer a wooden house to the holiday-maker, apart from a ger. What is the advantage of staying in a house?**

Our house is suitable for family holiday-makers. It provides all sorts of comfort with its bedroom, bathroom and kitchen required for a big family. The sweetness of woodsmell and comfort present the best rest to holiday-makers.

**I've understood from your talk that the "Red Rock" resort introduces a new appearance in the sector of tourism in the country. Finally, please tell us about the principle followed by your staff in management of services?**

All our staff work coordinated. Even every management-level staff participates in daily work. Everybody, treating customers sincerely, finds out necessary information step by step to ensure effective and good quality services. Since opening we've not done any marketing and advertisement. Customers visit us on being informed by holiday-makers who had visited us. And it is one of our work indicators. Effective management, hearty services and comfortable environment taken together form a quality operation and satisfaction. In this way we are establishing a new standard in service sector of tourism. Thus, we give attention to every detail of our operation.

**Thank you for your interview. We wish every success in your further activities!**